



ДОРНОД АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 02

Дугаар 8/10

Чойбалсан

Г Коронавируст халдварт /КОВИД-19/-ыг  
илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх,  
орлогыг зарцуулах, тайлагнах заавар  
батлах тухай

7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, 34.2.6, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3, 12.2.8, 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 470 дугаар тушаал, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 05/A/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварт /Ковид-19/-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, орлогыг зарцуулах зааврыг нэгдүгээр, антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний жишиг үнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга Ч.Оюунтунгалаг, Ахлах нягтлан бодогч Б.Батцэцэг нарт даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыгӨрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Б.Гантуяад даалгасугай.



Эрүүл мэндийн газрын даргын .....оны  
04. дугаар сарын 02.ны/ний өдрийн  
10 дугаар дүгээр тушаалын  
нэгдүгээр хавсралт

9031774 : 071911006

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫГ ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭГ ХИЙХ,  
ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЗААВАР**

**Нэг.** Коронавируст халдварт /Ковид-19/-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх заавар:

**1.1. Дараах тохиолдолд шинжилгээг төлбөртэй хийнэ.**

- 1.1.1. Иргэний хүсэлтээр,
- 1.1.2. Ашгийн зорилгоор тээвэр хийж буй ачаа тээврийн жолооч, туслах жолооч, ачааны эзэн,
- 1.1.3. Эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээрийн дэглэмийг зөрчсөн нь тогтоогдсон бол,
- 1.1.4. Гадаадын харьяат иргэн бол

**1.2. Дараах тохиолдолд шинжилгээний төлбөр авахыг хориглоно.**

- 1.2.1. 16 хүртэлх насны хүүхэд,
- 1.2.2. Жирэмсэн эмэгтэй,
- 1.2.3. Эх амаржсанаас хойш 56 хүртэлх хоногтой,
- 1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн,
- 1.2.5. 60 болон түүнээс дээш настай иргэн,
- 1.2.6. Хөдөлмөрийн чадвар алдалтай иргэн,
- 1.2.7. Хорт хавдартай иргэн,
- 1.2.8. Тархвар зүйн заалтаар шинжилгээнд хамрагдаж байгаа иргэн /сэжигтэй тохиолдол, ойрын хавьтал, хоёрдогч хавьтал/
- 1.2.9. Эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагатай иргэн,
- 1.2.10. Хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаантай иргэн,
- 1.2.11. Зорилтот бүлэг /цагдаа, мэргэжлийн хяналт, эрүүл мэнд, онцгой байдлын албан хаагч/
- 1.2.12. Албан үүргээ гүйцэтгэхэд тавигдах шаардлагаар шинжилгээнд хамрагдаж байгаа /томилолтоор явах, тусгай хамгаалалтын бүсэд нэвтрэх гэх мэт/ албан хаагч,

**Хоёр.** Коронавируст халдварт /Ковид-19/-ыг илрүүлэх шинжилгээний жишиг үнэ.

2.1. Антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний жишиг үнийг Монгол Улсын Шадар сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05A/12 тушаалаар баталсан 25.000 /хорин таван мянга/ төгрөгөөр тооцно.

**Гурав.** Коронавируст халдварт /Ковид-19/-ыг илрүүлэх шинжилгээ хийсэн төлбөрийг дараах байдааар авна.

3.1. Энэхүү зааврын 1.1.2 дахь заалтад заасан тээвэрлэлт хийлгүүлж байгаа компани, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь Хөлөнбуйр хяналтын цэгээр нэвтрэхээс

өмнө Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн 100070820401 дансанд төлнө.

3.2.Урьдчилж төлбөрийг тушаагаагүй тохиолдолд жолооч Хөлөнбуйр хяналтын цэг дээр Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн 100070820401 дансанд интернет банкаар төлж болно.

3.3.Бусад сумын нутаг дэвсгэрт төлбөртэй шинжилгээ хийлгэх тохиолдолд тухайн сумынхаа Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд төлбөрийг төлнө.

**Дөрөв.** Коронавируст халдварт /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээ хийсэн төлбөрийг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж дараах байдлаар зарцуулна.

4.1.Нэг удаагийн түргэвчилсэн оношлуур дагалдах хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдвартгүйтгэлийн бодис худалдан авах,

**Тав.**Төлбөртэй шинжилгээний орлого, зарцуулалтын тайланг тухай бүр байгууллагын шилэн дансанд ил тод, нээлттэй мэдээлнэ.

-ооОоо-

Эрүүл мэндийн газрын даргын .....оны  
...04 дугаар сарын ...02..ны/ний өдрийн  
.....дугаар/дүгээр тушаалын  
4/10 хоёрдугаар хавсралт

9031774 ф. 0719110008

АНТИГЕН ИЛРҮҮЛЭХ ЭСВЭЛ IGM, IGG ЭСРЭГ БИЕ ИЛРҮҮЛЭХ  
ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЖИШИГ ҮНЭ

№	Бүтээгдэхүүний нэр	Нэг хүнд ногдох өртөг /төгрөг/
1	AG ROT эсвэл IgM,IgG нэг удаагийн оношлуур	15000

ооОоо